

ЭРХ ЗҮЙН ХӨТЧИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, албан хаагчдын ажлын зохион байгуулалт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх албан хаагчдын эрх зүйн мэдлэг, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор салбарын хэмжээнд **“БИД ХАРИУЦЛАГАТАЙ АЛБАН ХААГЧИД”** аяныг зарласан.

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 16 заалт бүхий зөвлөмж, албан хаагчдын ажлын зохион байгуулалт, гүйцэтгэл, баримт бичгийн боловсруулалтын чанарыг сайжруулах чиглэлээр 11 заалт бүхий зөвлөмжийг тус тус хүргүүлэн ажиллаж байна. Зөвлөмжийн хэрэгжилт 80,6 хувьтай байна.

Эрүүл мэндийн газар болон анхан шатны 24 нэгжийн цахим хуудас, орон нутгийн иргэдийн идэвхтэй ашигладаг 18 фэйсбүүк бүлгэм зэрэг нийт 43 цахим хуудсуудад сэрэмжлүүлэг шторк 6, аудио мэдээлэл 16, зурагт хуудас 5 тус тус байршуулан хандалтын тоо өмнөх оны мөн үеэс 1941 буюу 84 хандалтаар өссөн байна.

Эрүүл мэндийн газрын 2023 оны 10 дүгээр сарын 20-ны өдрийн А/124 дүгээр тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу ажлын хэсэг томилж, удирдамжийн дагуу



Байгууллагын удирдлага, зохион байгуулалт, Хүний нөөцийн чиглэлээр хяналт үнэлгээ хийж, зөвлөн туслах ажлыг гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийн төвийн ажлын гүйцэтгэл, баримт бичгийн боловсруулалт, түүний чанар, эмх цэгц, хууль, эрх зүйн мэдлэг, архив албан хэрэг хөтлөлтийн стандарт гэх мэт дараах ажлуудыг сайжруулж, дутуу хийгдсэн ажлыг эрчимжүүлэх ажлын талаар зөвлөмж хүргүүлсэн.



Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд зөвлөн туслах чиглэлээр ажиллалаа.

- Ажилчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр гаргаж баталгаажуулсан төлөвлөгөө, түүний хэрэгжилт, зарцуулсан хөрөнгө, бичмэл тайланд тусгасан эсэх, тайланг хугацаанд нь ирүүлсэн байдал

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, албан хаагчдын

ажлын зохион байгуулалт, баримт бичгийн боловсруулалтын чанар, гүйцэтгэл, сахилга хариуцлага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч хоорондын харилцаа хандлагыг сайжруулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шинээр хэрэгжиж байгаа хуулийн тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт үзэж зөвлөмж өгсөн.



Зам тээврийн осол хэргийг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөнд оролцогчдын сахилга соёлыг дээшлүүлэх энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 5 сард аймгийн Цагдаагийн газартай хамтран “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Баянхонгор аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд Төсвийн тухай хууль,



санхүүгийн дотоод хяналтын талаар сургалт зохион байгуулах албан бичиг хүргүүлэн сургалтыг зохион байгуулав. Сургалтад нийт 25 хүн оролцсон.

Засгийн газрын “Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай албан даалгаврын хүрээнд салбарын хэмжээнд албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдөр **“Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Хүний амьдралын үнэ, цэнэ”** сэдэвт 120 хүний сургалтыг зохион байгуулсан.

Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан **“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”**, Засгийн газрын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан **“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”**-ыг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, бодлого шийдвэрийг сурталчлан таниулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн боловсролыг



дээшлүүлэх, мэдлэг олгох, архив албан хэрэг хөтлөлтийн стандарт, баримт бичгийн боловсруулалтын чанарыг сайжруулах зорилгоор 2023 оны 11 дүгээр сарын 29, 30-ний өдрүүдэд салбарын хэмжээнд эрүүл мэндийн төвүүдийн дарга нарыг **“Эрх зүйн хөтөч бэлтгэх, чадавхжуулах, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх”** сургалтыг 2 дахь жилдээ зохион байгуулж байна.

Сургалтаар:

- Шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлан таниулах, мэдээлэл өгөх
- Архив албан хэрэг хөтлөлтийн стандарт түүний хэрэгжилтийг хангах
- Хяналт шалгалтаар илэрдэг нийтлэг зөрчил, дутагдал, стандарт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгөх
- Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлт, тайлан гаргах,
- Авлигын эсрэг үйл ажиллагаа, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх,
- Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль,
- Эрүүл мэндийн салбарт сүүлийн 3 жилийн байдлаар гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, түүний шалтгаан нөхцөл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь,
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай,



Албан хаагчийн ёс зүй, ажил мэргэжилдээ эзэн байх, ур чадвартай байх, сэтгэл




зүтгэлтэй байхад чиглэсэн, ажил арга хэмжээ зохион байгуулах шинээр хэрэгжиж эхэлсэн хуулийг таниулах гэх мэт...сургалтууд зохион байгуулагдахаар бэлтгэл ажил хийгдэж байна.

Байгууллага хэмжээнд Авлигын эсрэг хуулийн 7.1.2 буюу бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах гэсэн хориглох заалтын хүрээнд “Нууц ба цэг” нэртэй контент, харьяа эрүүл мэндийн 14 байгууллагуудаас гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр контент тус бүр бэлтгэж ажилласан.

Эрүүл мэндийн салбарын хэмжээнд хуулийг нийтэд ойлгомжтой байдлаар таниулах чиглэлээр контент, гарын авлага бэлтгэх уралдаан зарлан 2023 оны 12 сарын 01нд дүгнэхээр ажиллаж байна.

Харьяа эрүүл мэндийн 14 байгууллагуудаас гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ирүүлсэн контент



ХЯНАСАН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА
Н.ЭНХЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН
ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН АСУУДАЛ,
ШАГНАЛ УРАМШУУЛАЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН АЖИЛТАН
Б.АЛТАНЦЭЦЭГ